

**МОСТ ФИНТЕК ХК**

Монгол Улс, Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг,  
8-р хороо Централ Тауэр 13-р давхар, 1313 тоот

Утас: 75052727

И-мэйл хаяг: info@most.mn

2024.07.24 № 101/24

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Мэдэгдэл хүргүүлэх тухай

Г САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНД

МОСТ Финтек ХК нь 2024 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаар хагас жилийн гүйцэтгэлээ дүгнэн хуралдсан бөгөөд мөн хурлаар компанийн хувьцааг эргүүлэн худалдан авах журмыг баталж, хувьцаа халааслах анхны шийдвэрийг гаргалаа.

Улаанбаатар Үнэт Цаасны Бирж дээр арилжаалагдаж буй компанийн хувьцааны ханшийг тогтворжуулах, үнэ буурахаас сэргийлэх болон компанид үр бүтээлтэй ажилласан ажилтнуудыг урамшуулах, харилцагч хамтрагч байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжих зорилгоор өөрийн гаргасан хувьцааны 5 хүрэхгүй буюу 1,4 хувийн хувьцааг эргүүлэн авахаар шийдвэрлэсэн болно.

Энэхүү шийдвэр, журам нь Монгол Улсын Компанийн тухай хууль болон төрөөс тогтоосон бусад хууль тогтоомжийн хүрээнд бүрэн нийцсэн бөгөөд ажиллагааг үнэт цаасыг анхдагч зах зээлд санал болгосон үнэт цаасны компани болох Ард Секьюритиз ҮЦК-р гүйцэтгүүлэхээр тогтлоо.

Арилжаа эрхлэх байгууллагаас сүүлийн 30 хоногийн хувьцааны жигнэсэн дундаж ханшийг гаргуулан авсны үндсэн дээр хувьцаа худалдан авах ханшийг тогтоосон ба уг ханш нь 39,6 төгрөг байв.

Бидний энэхүү шийдвэр нь хувьцаа эзэмшигчдийнхээ хөрөнгийн үнэ цэнийг хамгаалахын сацуу компанийн тогтвортой боловсон хүчний бодлого, үнэнч харилцагчдын хамтын ажиллагааны төлөвлөгөөнүүдэд ач холбогдолтой хэмээн найдаж байна.

Хувийг,

“Улаанбаатар Үнэт Цаасны Бирж ХК”, “Ард Секьюритиз ҮЦК ХХК”-д.

Хүндэтгэсэн,

ТУЗ-ИЙН ГИШҮҮН бөгөөд  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Хавсралт: .... хуудастай.

С.ОРГИЛ



## МОСТ ФИНТЕК ХК

Монгол Улс, Улаанбаатар хот  
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо  
Сэнтрал Тауэр 13-р давхар, 1313 тоот



Утас: 75052727  
Мэйл хаяг: info@most.mn

### МОСТ ФИНТЕК ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 07 сарын 23-ны өдөр

Дугаар # ВоDM ...../24

Улаанбаатар хот

#### Компанийн хувьцааг эргүүлэн худалдан авах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 49 дүгээр зүйл, 55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.7 дахь заалт, МОСТ Финтек ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.6, 6.8 дахь хэсэг, Улаанбаатар Үнэт Цаасны Биржээс гаргасан хувьцааны жигнэсэн дундаж ханшийн мэдээллийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хувьцаа эзэмшигч Нармандах овогтой Мөнхнасангаас 6,818,182 (зургаан сая найман зуун арван найман мянга нэг зуун наян хоёр) ширхэг хувьцааг нэг бүрийг нь 39,6 (гучин ес аравны зургаа) төгрөгөөр арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан эргүүлэн худалдан авахыг зөвшөөрсүгэй.
2. МОСТ Финтек ХК-ийн “Хувьцаа эргүүлэн худалдан авч, халааслах журам”-г энэ тогтоолын хавсралтаар баталж, цаашид дагаж мөрдсүгэй.
3. Компанийн хувьцааг эргүүлэн худалдан авах гэрээ, хэлцэл болон холбогдох бусад баримт бичигт компанийг төлөөлж, гарын үсэг зурах, хувьцааг хууль тогтоомжийн дагуу шилжүүлэн авах, халаасны хувьцаагаар бүртгэх, холбогдох төлбөр тооцоог хийж, зохион байгуулахыг гүйцэтгэх захирал (С.Оргил), хуульч( М.Номинчулуу), ерөнхий нягтлан бодогч (Н.Урнаа) нарт тус тус даалгаж, шаардлагатай бүрэн эрхийг 1 сарын хугацаанд олгосугай.
4. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн Зохицуулах Хороо, Улаанбаатар Үнэт Цаасны Бирж, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв зэрэг холбогдох эрх бүхий байгууллагуудад мэдэгдэл хүргүүлж, нийтэд мэдээллэхийг ТУЗ-ийн Нарийн бичгийн Дарга (М.Номинчулуу)-д даалгасугай.


ТУЗ-ИЙН ДАРГА



А. СУХДОРЖ



“МОСТ Финтек” ХК-ийн  
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
2024 оны 07 сарын 23-ний өдрийн  
хурлын 19 тоот тогтоолын Хавсралт



## “МОСТ ФИНТЕК” ХК-ИЙН ХУВЬЦААГ ЭРГҮҮЛЭН ХУДАЛДАН АВАХ, ХАЛААСЛАХ ЖУРАМ

### 1. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар “МОСТ Финтек” ХК (“Компани”)-ийн гаргасан нийт энгийн хувьцааг биржээр дамжуулан хувьцаа эзэмшигчээс эргүүлэн худалдан авч, халааслах ажиллагааг зохицуулна.

### 2. Холбогдох хууль, тогтоомж

- 2.1. Энэхүү журам нь Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, “МОСТ Финтек” ХК-ийн дүрэм, Үнэт цаасны бүртгэлийн журам, Улаанбаатар Үнэт Цаасны Биржийн Арилжааны журам, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын тухай журам болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд үйлчилнэ.
- 2.2. Энэхүү журам нь хууль, эрх зүйн хэм хэмжээний акттай зөрчилдсөн тохиолдолд холбогдох хууль, эрх зүйн хэм хэмжээний актыг баримтална.

### 3. Үйлчлэх хүрээ, зорилго

3.1. Энэхүү журам нь Улаанбаатар Үнэт Цаасны Бирж дээр нээлттэй арилжаалагдаж буй компанийн хувьцааг эргүүлэн худалдаж авах үйл ажиллагаанд үйлчилнэ.

### 4. Хувьцааг эргүүлэн худалдан авах нөхцөл

- 4.1. Эргүүлэн худалдаж авах хувьцааны нийт хэмжээ нь Компанийн гаргасан нийт энгийн хувьцааны 5 (тав) хувиас хэтрэхгүй буюу хувьцаа байна.
- 4.2. Эргүүлэн худалдаж авах хувьцааны төлбөрийг үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгөөр гүйцэтгэнэ.
- 4.3. Эргүүлэн худалдаж авах үйл ажиллагааг дараах хязгаарын хүрээнд явуулна:
- 4.3.1. Эргүүлэн худалдаж авах нэгж хувьцааны дээд үнийг өмнөх 30 хоногийн биржийн арилжааны жигнэсэн дундаж ханшаас хэтрэхгүй.
- 4.3.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн эргүүлэн худалдан авах энгийн хувьцааг багцаар худалдан авна.
- 4.3.3. Нэг өдөрт эргүүлэн худалдаж авах хувьцааны тоо Төлөөлөн удирдах зөвлөлийн эргүүлэн худалдаж авахыг зөвшөөрсөн энгийн хувьцааны тоогоор хязгаарлагдана.
- 4.3.4. Хувьцааг эргүүлэн худалдаж авах үйл ажиллагааг ажлын 7 хоногийн дотор гүйцэтгэнэ.
- 4.3.5. Эргүүлэн худалдаж авсан хувьцааны төлбөрийг энэ журмын 4.3.4 дэх хэсэгт заасан хугацаанд худалдагч талд шилжүүлнэ.
- 4.3.6. Эргүүлэн худалдан авсан хувьцааг дараах журмаар ашиглана.
- 4.3.6.1. Байгууллагад үр бүтээлтэй ажилласан ажилтан албан хаагчид, эрх бүхий албан тушаалтныг шагнаж урамшуулах;
- 4.3.6.2. Хамтрагч байгууллага, төсөл хөтөлбөрүүдэд урамшуулал зарлах, хамтран ажиллах, маркетинг борлуулалт, идэвхижүүлэлтийн хэрэгсэл болгон ашиглах;



4.3.6.3. Хуулиар хориглоогүй бусад.

**5. Хувьцааг эргүүлэн худалдаж авах үйл ажиллагаанд оролцогчийн бүрэн эрх**

- 5.1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”) дараах бүрэн эрхтэй:
  - 5.1.1. Энэхүү журамд нэмэлт, өөрчлөлт оруулах;
  - 5.1.2. Энэхүү журамд заасны дагуу эргүүлэн худалдаж авсан компанийн халаасны хувьцааг буцаан гүйлгээнд оруулах;
  - 5.1.3. Хувьцааг эргүүлэн худалдаж авах асуудлаар хяналт тавих, зөвлөмж гаргах, үүрэг даалгавар өгөх, зогсоох;
- 5.2. Компанийн Гүйцэтгэх захирал нь хувьцааг эргүүлэн худалдаж авахтай холбоотой дараах бүрэн эрхтэй:
  - 5.2.1. Хувьцааг эргүүлэн худалдаж авах ажиллагааг ТУЗ-өөс олгосон бүрэн эрх, энэхүү журамд заасан хүрээнд удирдан зохион байгуулах;
  - 5.2.2. Энэхүү журмын хэрэгжилт, эргүүлэн худалдаж авсан хувьцааны талаарх мэдээллийг тухай бүр ТУЗ-д тайлагнах;
  - 5.2.3. Хувьцааг эргүүлэн худалдаж авахтай холбоотой аливаа гэрээ, хэлцэл байгуулах, захиалгын хуудаст компанийн төлөөлж гарын үсэг зурах;
- 5.3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга дараах бүрэн эрхтэй:
  - 5.3.1. Хувьцааг эргүүлэн худалдаж авахтай холбоотой мэдээллийг олон нийтэд болон эрх бүхий этгээдэд мэдэгдэх, мэдээллэх, Компанийн хувьцаа эзэмшигчдэд заавар, зөвлөгөө өгөх, эргүүлэн худалдаж авсан хувьцааг Үнэт цаасны бүртгэлээс хасуулах, Үнэт цаасны бүртгэлийн мэдээлэлд өөрчлөлт оруулахтай холбоотой ажлыг тухай бүрт зохион байгуулах.

**6. Хүчин төгөлдөр болох хугацаа**

- 6.1. Энэхүү журам нь батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

“МОСТ Финтек” ХК